



ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/04.

Мөрөн сум

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Монгол Улсын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/545 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сургуулийн багш, ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ мөрдөх мэргэжлийн ёс зүйн дүрэм хэм хэмжээг мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол мэдээллийг хянаж шийдвэрлэх, ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулах ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	М. Ариунзул	(Физикийн багш)
Гишүүд:	А. Наранзул	(Сургалтын менежер)
	Н. Одончимэг	(Нийгмийн ажилтан)
	М. Саруул	(Англи хэлний багш)
	Э. Буяндэлгэр	(Бага ангийн багш)
	Э. Мөнгөнсүрэн	(Математикийн багш)
	Б. Нөхөрлөл	(Нярав)

2. Багш ажилтнуудад ёс зүйн хэм хэмжээг сурталчилан таниулах зөрчлөөс урьдчилан сэргийлэх хянан шийдвэрлэх ажлуудыг хариуцлагатай зохион байгуулахыг ёс зүйн зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  М. АРИУНАА

